

**МОНГОЛ ХЭЛНИЙ ТАЙЛБАР ТОЛЬД ҮГИЙН УТГЫГ
ТАЙЛБАРЛАХ ОНОЛ-АРГА ЗҮЙН АСУУДАЛД – 2**

**/Ус хийгээд түүнээс үүссэн байгаль цаг уурын
үзэгдлүүдийн нэрийг тайлбарлах тухайд/**

Ж. Сэржээ

Монгол хэлний тайлбар толиудад үгийн утгыг хэрхэн тайлбарлаж байгаа, тэдний алдаа хийгээд ололттой талыг нь монгол хүн бүрийн сайн мэдэх таван хошуу малын тухайт үг болон, байгалийн “УС” болоод түүнээс үүсэлтэй хур тундасны зүйлд холбогдох үгсийг хэрхэн тайлбарлаж байгаа баримтыг түшиглэн өгүүлэхийг миний бие зорьсон юм. Энэ хоёр бүлэг үгсийн эхнийх нь буюу малын тухайт үгс нь нүүдэлчин монголчуудын аж амьдралын өвөрмөц хэвшил, зан заншилтай нь нарийн холбоотой учир бусад хэлэнд байдаг ойлголтоос зарим ялгаатай, өөрийн үндэсний онцлог бүхий утгыг илэрхийлдэг гэж хэлж болох бол хоёрдугаарх бүлэг үгс буюу “УС”-тай холбоотой байгаль – цаг уурын үзэгдлүүд дэлхий нийтэд түгээмэл тохиолддог учир тэдгээр ойлголтуудыг илэрхийлдэг үгсийн утга бараг бүх хэлэнд онцгой ялгаагүй, нийтлэг байдаг. Өөрөөр хэлбэл УС-ыг мэдэхгүй, хэрэглэдэггүй хүн дэлхийд байхгүй, түүнийг илэрхийлэх үг байхгүй хэл ч бас дэлхийд байхгүй түгээмэл зүйл юм. Ийм учраас энэ хоёр үг, тэдэнтэй утгын хувьд шууд холбогдох бүлэг үгсийн утгыг монгол хэлний тайлбар тольд хэрхэн тайлбарлах тухай өгүүлэл бичиж, өнгөрсөн онд “Монгол хэлний тайлбар тольд үгийн утгыг тайлбарлах онол-арга зүйн асуудалд” нэртэйгээр. МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлал” эрдэм шинжилгээний бичиг сэтгүүлийн 2013 он. Боть XXXVIII (392), 79-86 дугаар талд эхний хэсгийг нь хэвлүүлсэн бөгөөд тэнд багталгүй үлдсэн “Ус” болон түүнээс үүсдэг байгалийн үзэгдлүүдийг нэрлэн заасан үгсийн утгыг монгол хэлний тайлбар тольд хэрхэн тайлбарлах боломжийг хөндсөн энэхүү өгүүллийг одоо хэвлүүлж байна.

Ямар ч монгол хүн “УС” гэдэг үгийг мэднэ. Түүнд “Ус уух уу?”, “Ус байна”, “Ус авъя” хэмээн хэлэхэд төвөггүй ойлгоно. Түүн шиг англи хүн “WATER”, орос хүн “ВОДА” гэдэг үгийг төвөггүй ойлгоно. Хэдийгээр илрэх хэлбэр талаасаа эдгээр үг өөр өөр боловч цаад агуулга /утга/ нь хүн бүхэнд тодорхой, хамгийн хэрэгцээтэй, хамгийн энгийн нэгэн зүйл бодисыг нэрлэж байгаа билээ. Энэхүү үгийг нэвтэрхий толь бичгүүдэд хэрхэн тайлбарласныг юуны өмнө авч үзье. Тухайлбал:

БРИТАННИКА нэвтэрхий толь бичигт: “Ус /water/ Устөрөгч хүчилтөрөгчөөс /H₂O/ бүрдэж, шингэн, хий /турбин дэх уур, ердийн усны уур/, хатуу төлөвт/мөс/ оршдог органик бус нэгдэл. Тасалгааны температурт ус нь өнгөгүй, үнэргүй, амтгүй шингэн юм. Хамгийн элбэг нэгдлийн нэг болох ус дэлхийн гадаргуугийн 75% орчмыг бүрхдэг. Амьдралын бүхий л үйл ажиллагаа уснаас хамааралтай, бусад олон бодисыг өөртөө уусгадаг нь магадгүй түүний хамгийн амин чухал чанар юм. Амьдралыг усанд /дэлхийн

далай тэнгис, жижиг уст цэгүүд/ үүссэн гэж үздэг; амьд организмууд услал уусмалуудыг /цус, хоол боловсруулах шүүс зэрэг/ биологийн процесс явуулах орчин болгон ашигладаг. Усны молекул тэгш хэмтэй бус, ЦАХИЛГААН ДИПОЛЬ-ийн моменттой учир ус, мөсөнд усны молекулуудын хоорондох УСТӨРӨГЧИЙН ХОЛБООС нь тэдгээрийг барьцалдуулахад чухал ач холбогдолтой. Усны нарийн нийлмэл хийгээд аномал физик, химийн шинж чанар /халах, буцлах цэг өндөр, ЗУУРАМХАЙ ШИНЖ, ГАДАРГУУН ТАТАЛЦАЛ, хатуу хэлбэрийнхээс шингэн төлөвийн нягт нь илүү байдаг/ нь өргөн түгсэн устөрөгчийн холбооноос үүдэлтэй юм. Ус юун түрүүнд давс, бас бусад уусагч бодисын оролцоогоор H^+ /эсвэл H_3O^+ /, OH^- ион болж ДИССОЦИАЦИ-д ордог; энэ нь хүчил, шүлтийн аль ч үйлчлэл үзүүлж болно. Ус олон тооны ДАВС, ЭРДЭС дотор холбогдож хязгаарлагдсан төлөвт /гидратацийн ус шиг/ тохиолддог. Усыг хөвүүлэгч орчин /цаас үйлдвэрлэл, нүүрсийг зайлж цэвэрлэх/, УУСГАГЧ, шингэлэгч бодис, хөргөлтийн шингэн, устөрөгчийн эх үүсвэр болгохоос гадна шүүлт, угаалга, уур үйлдвэрлэх, шохой, цемент зуурах, нэхмэлийн үйлдвэрлэл, хүхрийг уурхайгаас олборлох, ГИДРОЛИЗ, ГИДРАВЛИК, хоол ундаанд хэрэглэх зэргээр тоо томшгүй олон янзаар ашигладаг. ” гэж тайлбарлажээ. /BRITANNICA ширээний нэвтэрхий толь. НЕРКО. УБ. 2011 он, хуудас. 3293/.

Большой Энциклопедический словарь: ВОДА, H_2O , жидкость без запаха, вкуса, цвета/в толстых слоях голубоватая/, плотность $1,000 \text{ г/см}^3$ /3,98 градусов С/, тпл 0 С, ткипит 100 С. Одно из самых распространенных веществ в природе /гидросфера занимает 71% поверхности Земли/. Воде принадлежит важнейшая роль в геологической истории планеты. Без воды невозможно существование живых организмов /около 65% человеческого тела составляет вода/. Вода - обязательный компонент практически всех технологических процессов как промышленного, так и сельскохозяйственного производства. Вода особой чистоты необходима в производстве продуктов питания и медицине, новейших отраслях промышленности /производство полупроводников, люминофоров, ядерная техника/, в химическом анализе. Стремительный рост потребления воды и возросшие требования к воде определяют важность задач водочистки, водоподготовки, борьбы с загрязнением и истощением водоёмов. /Большой Энциклопедический словарь, М. 2000/

Монголын нэвтэрхий толь: “ H_2O үнэр, амт, өнгөгүй шингэн /зузаан үе нь цэнхэр өнгөтэй/, нягт нь $1,00 \text{ г/см}^3$ /3,98С/, 0° С -д хөлдөж 100° С -д буцална. Байгальд хамгийн их тархсан бодос /дэлхийн гадаргын 75%-ийг эзэлдэг/. Усгүйгээр амьд махбод байх нөхцөлгүй /хүний биеийн 65%-ийг ус эзэлнэ/. Ус бол үйлдвэр, хөдөө аж ахуйн технологийн бүхий л үйл явцын зайлшгүй шаардлагатай бүрдэл хэсэг юм. Эмнэлэг, хүнсний үйлдвэр, орчин үеийн үйлдвэрийн зарим салбарт /хагас дамжуулагч, цөмийн техник/ болон химийн задлан шинжилгээнд онцгой цэвэр ус шаардлагатай байдаг. Цэвэр усны хэрэгцээ, түүнд тавах техникийн шаардлага ихсэж байгаатай холбогдон ус цэвэрлэх, бэлтгэх, усны санг хамгаалах, орчны бохирдолтой тэмцэх асуудал орчин үед хурц тавигдаж байна.” /Монголын нэвтэрхий толь II боть, УБ. 2000 он. 922-р тал/ хэмээн тус тус тайлбарласан байна.

Одоо энэ үгийг тухайн хэлнүүдийн тайлбар толь бичгүүдэд хэрхэн тайлбарласныг авч үзье. Тухайлбал: “**THE CONCISE OXFORD DICTIONARY OF CURRENT ENGLISH**” Edited by H. W. FOWLER and F. G. FOWLER based on The Oxford Dictionary. Fifth edition Oxford University Press, 1964. Тайлбар толь “УС” гэдэг үгийг “Wa’ter¹ (waw-

), n. 1. Colourless transparent tasteless scentless compound of oxygen & hydrogen in liquid state convertible by heat into steam & by cold into ice, kinds of liquid consisting chiefly of this seen in sea, lake, stream, spring, rain, tears, sweat, saliva, urine, serum, etc. ” гэж тайлбарласан байна. /1471-р тал/ Өөрөөр хэлбэл УС-ыг “өнгөгүй, үнэр амтгүй, тунгалаг, халаахад уур болдог, хөлдөөхөд мөс болон хувирдаг устөрөгч хүчилтөрөгч хоёрын шингэн байдалд байгаа нэгдэл. Түүнээс далай тэнгис, нуур, гол горхи, булаг шанд, борооны ус үүсэн буй болох бөгөөд, бас нулимс, хөлс, шүлс, шээс зэрэг шингэнүүдийн ихэнхийг бүрэлдүүлнэ. ” гэж тайлбарласан байна.

Словарь русского языка, в четырех томах, М. 1981 тайлбар тольд: “ВОДА, -ы, вин. воду, мн. воды, дат. во’дам, и вода’м, твор. во’дами и вода’ми, предл. о во’дах и о вода’х, жс. 1. Прозрачная, бесцветная жидкость, образующая ручьи, реки, озера, моря и представляющая собой химическое соединение водорода с кислородом. ” хэмээн тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл УС-ыг “гол горхи, нуур, тэнгисийг үүсгэн буй болгогч устөрөгч хүчилтөрөгчийн химийн нэгдэл болох тунгалаг, өнгөгүй шингэн” гэж тайлбарласан байна.

УС гэдэг үгийг Товч тайлбар тольд: “устөрөгч хүчилтөрөгч хоёрын химийн цэвэр нийлэл болох өнгөгүй, тунгалаг, шингэн зүйл,” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “устөрөгч хүчилтөрөгч хоёрын химийн цэвэр нэгдэл болох өнгөгүй, тунгалаг, амт үнэргүй нэгэн зүйл шингэн” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “дөрвөн махбодын дотоод шингэн болоод нойтныг нь”, **Хорин наймт тайлбар тольд:** “Чийгтүүлэн нойтон болгох чанартай, цэвэртээ угаан арилгах хэрэглэлтэй, уруу одох явдалтай, ундаа бүхний уг хөрөнгийг ус хэмээмүй” гэсэн бол, **Хорин нэгт тайлбар тольд:** “таван махбодын дотоод нэг зүйл. Гол булаг аливаа газраас урсан гарсан тунасны нь цөм ус хэмээмүй” гэжээ. **Монгол хэлний тольд:** “Хоёр устөрөгч атом ба нэг хүчилтөрөгч атом нийлээд бүтсэн хүчилтөрөгч устөрөгчийн хамгийн дөхөм нэгдвэр. Өнгө, үнэр ба амт үгүй шингэн биет. Баримжаа агаар мандлын дарц дор цельсийн тэг градуст хөлдөж, цельсийн 100 градуст буцална. Цельсийн дөрвөн градусын үед усны нягтац нь хамгийн их, хувийн жин нь нэг. ” хэмээн тайлбарлажээ.

Дээрх тайлбаруудаас үзвэл нэвтэрхий толь бичгүүдэд УС-ны физик, химийн шинж чанаруудыг шинжлэх ухааны үүднээс нарийвчлан тайлбарласнаар үл барам үйлдвэрлэл, аж ахуйд хэрхэн ашиглаж байгааг ч дэлгэрэнгүй өгүүлжээ. Тэгвэл тайлбар толь бичгүүдэд “Устөрөгч хүчилтөрөгч хоёрын химийн нэгдэл” гэдгээс бусад нь энгийн хүмүүс өөрийн таван мэдрэхүйгээрээ дамжуулан шууд мэдэрч байгаа хамгийн энгийн, гадаад шинж чанаруудыг нь түшиглэн тайлбарласан байна. Ийнхүү тайлбар толийн тайлбар нь тухайн хэлээр хэлэлцэгч нийт хүнд зориулан, бүхний мэдэх энгийн үгээр товч тодорхой өгүүлсэн байдаг. Нэвтэрхий толь, тайлбар толь хоёрын гол ялгаа үүнд оршино. Монгол хэлний тайлбар толиудын нэлээд тайлбар энэхүү шаардлагыг хангаж чадахгүй, нэг хэсэг нь нэвтэрхий толийн тайлбар руу хэт хэлтийсэн байхад, нөгөө хэсэг нь аль ч толийн тайлбар хэмээн хэлж болохооргүй, жирийн хүн уншаад шууд ойлгоход төвөгтөй тайлбарласан жишээ олон бий. Тухайлбал дээр дурдсан “дөрвөн махбодын дотоод шингэн болоод нойтныг нь”, “таван махбодын дотоод нэг зүйл, “Хоёр устөрөгч атом ба нэг хүчилтөрөгч атом нийлээд бүтсэн хүчилтөрөгч устөрөгчийн хамгийн дөхөм нэгдвэр гэх мэтийн тайлбаруудыг дурдаж болно. Түүний оронд “Булаг шанд, гол горхи, нуур

цөөрөм, далай тэнгисийг бүрдүүлж байгаа тунгалаг, өнгөгүй, байгалийн шингэн биет
“хэмээн тайлбарлавал хэн ч ойлгоно.

УУР гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “шингэн зүйлийн халахад гарах нойтон хий” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “шингэн зүйлийн халахад гарах нойтон хий.” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “аливаа юмнаас утааны адил борхирон гарахыг нь”, **Хорин наймт тайлбар тольд:** “Тэнгэр газрын хооронд түгээмэл тархсан түмэн бодисын эдгэж тогтнохын шүтээнийг уур хэмээмүй. Бас аливаа ус жигнэгдэн дээш гарах хийгээд хавар, зун, намар, өвлийн улирал эхлэхийг уур хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Тэнгэр, газар, хүн, түмэн юмны тогтносныг нь уур хэмээмүй. Жич, аливаа юмнаас утаа адил бургиран гарахуйг нь уур хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “шингэн төлөвт бодисын хийжих” гэх мэтээр тайлбарласан байна. Уур гэдэг үгээр илэрч байгаа ухагдахууны үндсэн мөн чанар бол **усны хийн төлөвт шилжих үзэгдэл** тул энэ үгийн тайлбар үүнд чиглэх ёстой. Тухайлбал ус хийн төлөвт ямар нөхцөлд шилждэг, хийн төлөвт орсон усны шинж чанар нь яаж өөрчлөгддөгийг тайлбарт тусгах нь зүйтэй. Дээрх тайлбаруудыг үзвэл энэ шаардлагыг хангаж чадаагүй нь илт байна. Тухайлбал шингэн зүйлийн халахад гарах нойтон хий гэсний шингэн зүйл гэдэгт уснаас гадна мөнгөн ус хүртэл маш олон зүйл багтана. Зарим шатамхай, тэсрэх аюултай шингэн зүйлийг халахад уур болохгүй, шууд аюул учруулна. Иймд шингэн зүйл гэснийг шууд утгаар нь буюу “ус хийгээд ихэнхи нь уснаас бүрдсэн шингэн зүйл агаарт дэгдэн хий болох үзэгдлийг уур гэнэ. Уур нь хүйтэн сэрүүн агаарт цагаан өнгөтэй болно. Байгальд оршин байгаа уур нь манан, будан, үүл гэх мэтийн олон хэлбэртэй” хэмээн тайлбарлаж болмоор байна. Уур гэдэг үгийн тайлбар нь манан, будан, үүл гэдэг үгсийг тайлбарлах үндэс болно.

ҮҮЛ гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “агаарт хуран цугларсан усны уур” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “агаарт хуран цугларсан усны уур,” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “газрын чийгт уур дэгжин хоосон өндөр агаарт хүрч түгсэнийг нь”, **Хорин наймт тайлбар тольд:** “газрын чийгний уур дээш хөөрч, хоосон агаарын жихүүн амьсгал лугаа учирч царцаад наран сарны наагуур хэсэг хэсгээр түгж өнгөрөх ба нэлэнхээр бүрхэж хур бороог буулгахыг үүл хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “газраас чийгт уур дэгжин, хоосон өндөр агаарт хүрч түгсэнийг нь үүл хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Газраас чийгт уур дэгжин, хоосон өндөр агаарт хүрч түгсэнийг нь үүл хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “Агаарт хөвөн харагдах усан дусал буюу мөсөн талстуудын хурдас. Голдуу усны уур агаарт хөрч царцсанаас буй болдог. Давхаргатсан, багларсан буюу долгиотсон хэлбэртэй. Үүлний нүүдэл нь агаарын урсгалын чиглэл, хурдацыг илэрхийлэх бөгөөд үүлний хэлбэрийн хувиралт нь агаар мандлын бүтцийн байдал ба цаг уурын хувиралтыг илэрхийлнэ” гэх мэтээр тайлбарласан байна. Эдгээр тайлбар бүгд үнэний хувьтай бөгөөд нэгийнх нь дутуу тайлбарыг нөгөөгөөр нь нөхөн нэгтгэвэл сайн тайлбар болно. Тухайлбал, “агаарт хуран цугларсан усны уур” гэсэн Товч тайлбар толь, Дэлгэрэнгүй тайлбар толь хоёрын тайлбарт дутагдаж буй хаанаас яаж хуран цугласан, ямар шинж чанартай болсон уур вэ? гэдгийг нэмээд “газрын гадаргуу, усны мандаас хөөрөн дэгдэж, агаар мандалд хуралдан, янз бүрийн хэлбэртэй, цагаан, бөөн бараан өнгөтэй харагдах усны уур. Хүйтэн жихүүн агаар мандалд жижиг усан дусал, бяцхан мөсөн талстууд болон хувирсан усны уур бороо, мөндөр, цас болон газрын гадаргууд бууна. ” гэж тайлбарлаж болох юм.

МАНАН гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “усны уур дүүрсэн тунгалаг бус агаар,” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “хэсэг газарт тогтсон усны уур бүхий тунгалаг биш агаар” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “аливаа чийгт уур нэг газарт багларсныг нь”, **Хорин наймт тайлбар тольд:** “Хааяа ус чийгний уур дээш дэгдэж газар дээгүүр харанхуйлан байхыг манан хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “аливаа уур нэг газарт багларсныг манан хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Аливаа уур нэгэн газраа багларсныг манан хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “газрын гадаргаас ойр байгаа уур бүхий агаар. Манан будан /холын барааг халхлан бүрхсэн их манан/ хэмээн тайлбарлажээ.

Үүл, манан, будан гэсэн байгалийн гурван үзэгдлийн мөн чанар бол угтаа бүгд адилхан, агаарт дэгдсэн усны уур билээ. Тэгвэл энэ гурван үзэгдэл юугаараа ялгаатай вэ? Үүнийг л тайлбарт тусгаж өгвөл энэ гурван үгийн утгын ялгаа гарна. Иймээс манан гэдэг үгийг “газрын гадаргуу, усны мандал дээр хэсэгчлэн тогтсон, харагдах орчин хязгаарлагдмал өтгөн, цагаан өнгөтэй усны уур” гэж тайлбарлах боломжтой юм.

БУДАН гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “Усны уур хуралдсаны улмаас агаарын хий дээд талаараа тунгалаг, доод талаараа бүдэг бүрхэг болох.” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “маш жижиг усан дуслуудаас бүрэлдсэн манан” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “газрын уур дээш дэгжих ба тэнгэрийн уур дорогш залгамжлахгүй утаан дор адил бургим уур гарахыг нь”, **Хорин наймт тайлбар тольд:** “Газрын уур дээш дэгжих ба тэнгэрийн уур дорогш залгамжлахгүй утаан дор адил бүрхэм уурыг будан хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “газрын уур дээш дэгжих ба тэнгэрийн уур доош залгамжлахгүй утаанд адил бургим уурыг будан хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Газрын уур дээш дэгжих ба тэнгэрийн уур доош залгамжлахгүй утааны адил бургим агаарыг будан хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “манан тоос, нимгэн үүл бүхий бүдэг хуйсгар үзэгдэл. Будан татах /алсын уул толгодын оройгоор будан суунаглан харагдах/” гэж тайлбарлажээ. Эдгээр тайлбарыг уншаад монгол хүний мэддэг будангийн тухай ер сэтгэлд буухгүй байна. Харин дээр өгүүлснийхээ дагуу “газрын гадаргуу, усны мандал дээр агаарт хөөрөн үүл толгод, өндөрлөг газрын оройд бүрхэн суусан манан” хэмээн тайлбарлаж болох юм.

Харин Ус цаг уурын станц харуулууд дээр агаарын үзэгдлийг ажиглах “Ус цаг уурын албаны заавар”-т: Манан гэдгийг “агаарт нүдэнд үл үзэгдэх жижиг усан дуслууд их хэмжээгээр агуулагдсанаас алсын бараа 1000 м-ээс бага болох үзэгдэл” гэсэн бол Буданг “Энэ нь маш сийрэг манан юм. Нүдэнд үл үзэгдэх усан дусал буюу мөсөн талст агаарт агуулагдсанаас агаар бага зэрэг бүдгэрч, алсын барааны харагдалт 1000 м-ээс их 10 км-ээс бага байна. /13:122-р тал/ гэж энэ хоёр үзэгдлийн хүний нүдэнд үзэгдэх орчны нь алсгалтыг үндэслэн ялгасан байна.

ХУР гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “Агаарын тунадас, цас бороо” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “агаарын тунадас, цас бороо,” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “бороо”, **Хорин наймт тайлбар тольд:** “Газрын чийгт уур дэгжин гарч, өндөр хоосонд хүрэхүй лүгээ тэнгэрийн хүйтэн уурт тохиолдон цантсанаас үүл болж дахин доош буух ерөнхий нэрийг хур хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “газраас дэгдсэн уурын хүйтэн агаарт цохигдон хурсан тундас буюу царцдас” хэмээн тус тус тайлбарласан байна. Энэ үгийг **Хорин наймт тайлбар толь** нэлээд сайн

тайлбарласан гэж бодож байна. Өөрөөр хэлбэл “Агаар мандалд үүл болон хөөрсөн усны үүр хүйтэн агаарын нөлөөгөөр ишигэн, хатуу хэлбэрт шилжин хуримтлагдаж доош буух тундасны ерөнхий нэр” гэх буюу “Үүлнээс тундас болон буух цас, бороо” гэсэн ч болох юм. Хур гэдэг үгийг ихэвчлэн бороо гэдэг үгтэй хамтруулан **хур бороо, бороо хур** гэж хоршин хэрэглэдэг.

БОРОО гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “Агаарын тундасны нэг зүйл болох усан дуслууд.” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “Агаарын тундасын ууршин унасан усан дуслууд,” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “Газрын уур дэгжин тэнгэрийн уур бууж тохиолдон үүлнээс буун ирэх усыг”, **Хорин наймт тайлбар тольд:** “Газрын чийг уур болон маш өндөр дэгдэж, огторгуйн жихүүн амьсгал лугаа золголдон улмаар арвидаж цугларан үүл бололцсоноос дорогш бууж ирэх усны дуслыг бороо хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “газрын уур дэгжин өндөр хоосонд хүрэх ба тэнгэрийн уур тохиолдон бууж үүлнээс цантан тосон тохирох усыг бороо хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Газрын уур дэгжин өндөр хоосонд хүрэх ба тэнгэрийн уур тохиолдон бууж, үүлнээс цантан дусан тохирохуй усыг бороо хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “үүлний давхаргаас газар дээр буусан ус. Үүлний давхарган дахь бичил усан мөхлөгийн эзлэхүүн нь нэмэгдэж агаар дунд хөвж чадахгүй болсон үед бороо болон буудаг.” гэж тус тус тайлбарласан байна.

Бороог мэдэхгүй хүн байхгүй. Харин бид байгалийн ямар үзэгдлийг бороо гэж нэрлэдэг вэ, Бороо яаж бий болдог вэ, Бусад хур тундаснаас юугаараа ялгаатай вэ гэдгийг бодолцон энэ үгийг тайлбарлах нь ойлгомжтой. Энэ шаардлагын үүднээс үзвэл монгол хэлний товч тайлбар толь болон дэлгэрэнгүй тайлбар толийн тайлбар дэндүү чамлалтай. Харин Хорин наймт, Хорин нэгт болон Гучин зургаат тайлбар толиудын тайлбар нэлээд үндэслэл сайтай байх боловч Монгол хэлний толийн тайлбар нилээд боломжийн болсон санагдана. Энэ бүхнээс үндэслэн бороо гэдэг үгийг “Үүл болон хөөрсөн усны үүр өндрийн хүйтэн агаарт хөрөн, жижиг усан дуслуудыг үүсгэх ба тэдгээр дуслууд томорсоор агаар мандалд биеэ даахгүй болох үедээ газарт буух” гэх буюу товчоор “Үүл болон хөөрсөн усны үүр өндрийн хүйтэн агаарт хөрөн, жижиг усан дуслууд болж газарт буух”, эсвэл “Үүлнээс буух усан дусал хэлбэрийн тундас” гэж хамгийн товчоор тайлбарлаж болох юм.

МӨНДӨР гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “жижигхэн бөөрөнхий мөсөөр орох хур. агаарын тунадас” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “жижиг бөөрөнхий хэлбэртэй агаарын мөсөн тунадас” хэмээн тайлбарлажээ. **Хорин наймт тайлбар тольд:** “Газрын чийг уур дээш мандаж, огторгуйн жихүүн амьсгалд хөлдөж бүдүүн нарийн мөхлөг мэт мөс болон хур бороо лугаа холилцон буухыг мөндөр хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “билгийн уур хүчир болж өндөр хоосон жихүүн уурт бөөмнөлдөж бороо холин унан ирэх мөсийг мөндөр хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Билгийн уур хүчир /чийрэг/ болж өндөр хоосон жихүүн агаарт бөөмнөлдөж бороо холин унан ирэх мөсийг мөндөр хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “аянгат агшин борооны хамт агаараас буудаг 5-50 миллиметр хир диаметр бүхий мөсөн мөхлөгүүд. Агаарын ширүүн урсгалд туугдсан азарган борооны үүл хуйлран дээр дороо орох үед түүний доторх туйлаадас нь цасан лавс, усан дусалтай нийлэлдэн бүдэг тунгалаг алаглан давхаргатсан мөсөн мөхлөг болон барилдаж томроод биеэ даахгүй болж газарт буудаг байна.

Мөндрийн орох цаг урт биш, томхон мөхлөгт мөндөр бол таримал ба хүн амьтныг шархдуулан хөнөөх аюултай” гэж тайлбарласан байна.

“Ус цаг уурын албаны заавар”-т: мөндрийг “Янз бүрийн хэлбэртэй мөсөн ширхэгтэй юм. Мөндөр тунгалаг биш цөмтэй, гадуураа нэг буюу хэд хэдэн давхар мөсөн үеэс тогтсон байна. Мөндрийн голч нь 5 мм орчим байх боловч зарим тохиолдолд хэд хэдэн см хүрнэ. Хүндийн хэмжээ нь хэдэн граммаас зарим тохиолдолд хэдэн зуун грамм хүрдэг. Мөндөр дулаан улиралд борооны бөөн үүлнээс орох бөгөөд ихэнх тохиолдолд аадар бороотой холилдож орно” /13:120-р тал/ гэж тодорхойлжээ.

Эдгээр тайлбарууд үндсэндээ боломжийн болсон ба **Монгол хэлний толийн тайлбар хэтэрхий нэвтэрхий толийн шинжтэй болжээ.** Бидний бодлоор, мөндөр гэдэг үгийг “Дулааны улиралд үүлэн доторхи борооны усан дуслууд өндрийн хүйтэн агаарт огцом хөлдөж, янз бүрийн хэмжээ бүхий тунгалаг бус цөмтэй мөсөн мөхлөг болон буух тундас” хэмээн тайлбарлаж болно.

МӨС гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “Хөлдсөн ус, хөлдүү ус”, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “Хөлдсөн ус, ус хөлдөж хатуу төлөвт орсон нь” гэсэн бол, **С. Шагжийн тайлбар тольд:** “Билгийн хур багшран мөс хөлдсөнийг нь”, **Хорин наймт тайлбар тольд:** “Өвлийн улирлын хүйтэн жаварт ус хөлдвөөс мөс хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “Билгийн уур багшран ус хөлдсөнийг мөс хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Билгийн уур багшран ус хөлдсөнийг мөс хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “Цельсийн тэг буюу түүнээс доромш градус дахь барилдан хатуурсан ус” хэмээн тус тус тайлбарлажээ. Эдгээр тайлбар бүгд мөсний мөн чанарыг илэрхийлж байгаа ба “хөлдөж хатуу төлөвт орсон ус” гэвэл илүү оновчтой, тодорхой тайлбар болно.

ЦАС гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “Жихүүн цагт агаарт усан талстууд бий болж цав цайм унгарил ширхэгүүдээр буух агаарын тунадас, мөнхүү тунадас бууж газрын гадаргыг бүрхсэний нь” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “Өвлийн цагт агаарт усан талстууд бий болон улмаар газрын гадаргуу дээр буух агаарын тунадас” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “Хүйтэн цагт аргын уур газрын хуурай жихүүн уур нийлэлдэж царцан цагаан унгирал мэт болж унан ирэхийг нь”, **Хорин наймт тайлбар тольд:** “Хүйтэн цагт аргын уур огторгуйд тогтсон үест газрын чийгт уур дээш гарч агаарын жихүүнд хөлдөж, үүл болоод түүнээс цав цагаан унгирал мэт будран буухыг цас хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “Өвлийн цагт аргын уур хоосон өндөрт ахуйд газрын хуурай жихүүн уур дор үүл болж устан унан ирж жихүүн агаарт хөлдөж цав цайм цэгэн унгирал мэт унан ирэхийг нь цас хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Өвлийн цагт аргын уур хоосон өндөр ахуйд газрын хуурай жихүүн уурнаа үүл болж усдан унан ирж, жихүүн агаарт хөлдөж, цав цайм цэгээн унгирал мэт унан ирэхийг цасан хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “Агаарын дулаан тэг градусаас доромшлох үед агаар мандалд дэгдээд байсан усны уур цагаан өнгөтэй талст болон царцаад газарт бууж ирдэг царцдасан хур. Талстын олонх нь зургаалжин байдаг.” гэж тайлбарлажээ. Эдгээр тайлбар бараг бүгд нэвтэрхий толийн шинжтэй болсон байна.

Өвлийн улиралд үүлнээс буудаг хур тундасыг цас гэдгийг хүн бүр мэднэ. Энэ үгийг тайлбарлахын тулд үүл хэрхэн үүсдэг, үүлэн дэх уур хэрхэн цас болж хувирдагийг мэдэх хэрэгтэй болно. Өвлийн цагт ч гэсэн тэнгэрийн үүл усны уураас бүрдсэн байдаг. Харин энэ уур хүйтэн агаарт царцан зөв зургаан өнцөгт, зургаан хошуут од зэрэг

хэлбэртэй цагаан өнгөтэй талстууд болж газарт унана. Иймд цас гэдэг үгийг товчоор “Агаарын температур тэг хэмээс /0°/ доош байх хүйтний улиралд үүлнээс буух тундас” хэмээн тайлбарлаж болох юм.

Уснаас үүсдэг дараагийн нэгэн бүлэг байгаль - цаг уурын үзэгдэл болох **шүүдэр, хяруу, цан** гэдэг үгсийг хэрхэн тайлбарлаж болох вэ?

ШҮҮДЭР гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “агаараас бууж ирдэг маш жижиг усан дуслууд” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “газрын хөрсөнд ойр байгаа усны уур шөнийн сэрүүнд газар дээр бууж, өвс ургамлын толгойд усан дуслууд бөнжигнөн тогтсон нь” хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “шөнө уурын чийгтсэн шимийг”, **Хорин наймт тайлбар тольд:** Чийгтэй шөнийн уурыг шүүдэр хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “шөнө уурын чийгтсэн шимийг шүүдэр хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Шөнө уурын чийгтсэнийг шүүдэр хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “шөнийн сэрүүнд халуунаа алдаад газар дээр буухдаа өвс ургамлын дээгүүр бөнжигнөн тогтсон ханамал уурын жижиг дуслууд” гэх мэтээр тайлбарласан байна. “Ус цаг уурын албаны заавар”-т: “Шүүдэр нь агаарын температур 0°C-аас дээш байх үед газрын гадарга, өвс ургамал болон бусад элдэв биетүүд дээр тогтсон дусал юм. Шүүдэр тогтож байгаа гадаргын температур нь орчны агаарын шүүдэр унах цэгийн температураас бага /хүйтэн/ байх тохиолдолд шүүдэр үүснэ. Салхигүй буюу зөөлөн салхитай шөнө гадарга дулаанаа алдаж хөрөх явдал нь шүүдэр үүсэх үндсэн нөхцөл болно” /13:121-р тал/ хэмээн тодорхойлсон байна.

Газрын чийг ихтэй, ялангуяа өдөр нь бороо орсон зуны цэлмэг, салхигүй шөнө хөрсөн дээр бууж хоносон усыг шүүдэр гэдгийг бид мэднэ. Битүү үүлтэй бүрхэг шөнө шүүдэр унадаггүй. Шүүдрийн энэ шинж чанарыг үндэс болговол, **Дэлгэрэнгүй тайлбар толийн** тайлбар нилээд ойртжээ. Өөрөөр хэлбэл “Зуны улиралд газрын гадарга орчимд үүсэх усны уур салхигүй цэлмэг шөнийн сэрүүнд хөрч жижиг усан дуслууд болон хувирснаас газрын гадарга, өвс ургамлын толгойд бөнжигнөн тогтох үзэгдэл” хэмээн тайлбарлаж болмоор байна. Агаарын доод мандлын битүү үүл нь өндрийн сэрүүн агаарыг газрын гадарга руу нэвтрүүлэхгүй хаалт болдог тул бүрхэг шөнө шүүдэр унадаггүй.

ХЯРУУ гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “газарт бууж тогтсон шүүдрийн хүйтэнд царцсан цан” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “газарт унасан шүүдрийн, хүйтэнд царцсан цан”. хяруу унах /агаар доторх чийг шөнийн жихүүнд царцаж, жижиг талст болон газар дээр цайран бүрхэх/ хэмээн тайлбарлажээ. **С. Шагжийн тайлбар тольд:** “шүүдэр царцсаныг нь”, **Хорин наймт тайлбар тольд:** “Шүүдэр царцсаныг хяруу хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “шүүдэр царцсаныг хяруу хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** Шүүдэр царцсаныг хяруу хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “агаарын дулаан тэг градусаас дороз буурахад газрын гадаргуугийн агаар доторх усны уур царцаад газрын хөрсийг бүрхэн буусан жижиг цагаан мөсөн талстууд” гэх мэтээр тайлбарласан байна. Тэгвэл “Ус цаг уурын албаны заавар”-т: “Хяруу нь 0°C-аас бага /-/ температуртай байх үед гол төлөв шөнө буюу оройн цагаар, өвлийн улиралд өдрийн цагт газрын гадарга болон түүний дээрх янз бүрийн биетүүд дээр тогтсон талстаас бүрдсэн тунадас юм...Агаарын доторх усны уур элдэв биетийн гадаргад хүрч шууд мөс болон хөлдсөнөөс хярууны талстууд үүсдэг. Хяруу нь шүүдрийн нэгэн адил

зөөлөн салхитай цэлмэг шөнө газрын гадарга болон элдэв биетүүд хүчтэй хөрөх боломжтой нөхцөлд үүсдэг” /13:121-р тал/ гэжээ.

Цэлмэг тогтуун шөнө газрын гадарга орчимд үүссэн усны уур зуны улиралд шүүдэр болон хөрсөн дээр буудаг бол намар оройн сэрүүн цаг болохоор шүүдрийн усан ширхэгүүд царцан, цас шиг цагаан өнгийн жижиг мөсөн талстууд болж газрын хөрсөн дээр тогтохыг хяруу гэж хэлдэг билээ. Иймд дээр дурдсан толиудын тайлбарыг боломжийн болсон хэмээн үзэж байна.

ЦАН гэдэг үгийг **Товч тайлбар тольд:** “хүйтний цагт ус чийг зэргээс дэгдэж гарсан уур царцаж тогтсон цас мэт зүйл” гэсэн бол, **Дэлгэрэнгүй тайлбар тольд:** “хүйтний улиралд ус чийг зэргээс дэгдэж гарсан цас мэт царцсан уур” хэмээн тайлбарлажээ. **Хорин наймт тайлбар тольд:** “Хүйтэн цагт уур амьсгалын чийг хөлдөж цагаан хяруу адил болохыг цантмуй хэмээмүй”, **Хорин нэгт тайлбар тольд:** “сахал, үс, өвс, модны зэргийн юм жихүүн ууранд цайн устсаныг нь цантаж хэмээмүй”, **Гучин зургаат тайлбар тольд:** “Өвс модны зэргийн юм жихүүн ууранд цайн устсаныг цантажи хэмээмүй”, **Монгол хэлний тольд:** “хүйтэн цагт юмны дээр тогтон царцсан уурын цас” хэмээн тус тус тайлбарласан байна. “Ус цаг уурын албаны заавар”-т: “Гол төлөв манантай, салхитай үед модны мөчир, төмөр утас, өвс ургамал дээр манангийн хэт хөрсөн дуслууд шавж хөлдсөнөөс тогтсон цасархаг сэвсгэр бөөрөнхий ширхэгтэй тунадас юм” хэмээн тодорхойлжээ. Цан ба цантах гэдэг үзэгдэл өвлийн хүйтэн улиралд ихэвчлэн тохиолдох ба “манан бүхий хүйтэн агаарт усны уур мод бутны мөчир, гэр байшингийн дээвэр, хашаа хороо зэрэг хаа сайгүй цас шиг жижигхэн мөсөн талстууд болон тогтох” –ыг цантах гэх ба харин тэрхүү жижиг цагаан талстыг нь цан гэдэг. Мөн хүйтэн агаарт хүн, амьтны ам хамраас гарах халуун хий нүд хөмсөг, малгай ороолт зэрэгт царцан тогтохыг бас цан гэнэ. Иймд цан гэдэг үгийг “өвлийн улиралд хүйтэн агаарт гарч царцсан уур” гэж тайлбарлаж болмоор санагдана.

Бидний тайлбарлахыг оролдож байгаа эдгээр үгээр илэрч буй цаад юм үзэгдэл, ухагдахуун нь зөвхөн монголд байдаг бус, зөвхөн монгол хүн л мэддэг юм биш, дэлхийн олон газарт түгээмэл байдаг үзэгдлүүд учраас мал, үхэр адуу гэх мэтийн үгийг бодвол тайлбар нь ч олон хэлэнд нийтлэг байх нь ойлгомжтой. Гэвч тухайн ард түмний амьдралын хэвшил, нөхцөлтэй уялдан бага зэргийн ялгаа бас л гардаг. Тухайлбал жилийн дөрвөн улиралд байгалийн бэлчээрт малаа маллан амьдардаг монголчуудын хэлэнд манан будан, цан, хяруу гэх мэтийн үгийн утгыг нэлээн нарийн ялгадаг байхад суурин амьдралтай ард түмний хэлэнд тийм нарийн ялгах хэрэгцээ, шаардлага үгүй байдаг. Иймд аливаа үгийн утгыг толь бичигт тайлбарлахдаа маш сайн судалгаа хийж, нийтлэг адил тал, нийтлэг бус өвөрмөц ялгааг нь олж тогтоож байх нь чухал байна.

Нүүдэлчин монголчуудын аж амьдралын өвөрмөц хэвшил, сэтгэл зүйн онцлог, зан заншилтай нь нарийн холбоотой, бусад хэлэнд байдаг ойлголтоос зарим ялгаатай, өөрийн үндэсний онцлог бүхий утгыг илэрхийлдэг гэж хэлж болох “малын тухайт үгс” хийгээд дэлхий нийтэд түгээмэл тохиолддог учир утга нь бараг бүх хэлэнд онц ялгаагүй, нийтлэг байдаг “УС”-тай холбоотой байгаль – цаг уурын үзэгдлүүдийн нэрсийг монгол хэлний тайлбар толиудад тайлбарлаж байгаа баримтад тулгуурлан задлан шинжилснийхээ үр дүнг онол-арга зүйн талаас нь дараах байдлаар товчхон илэрхийлж болох юм.

1. Тайлбар тольд үгийн утгыг тайлбарлахын тулд маш нарийн судалгаа хийх шаардлагатай байдаг. Судалгаагүйгээр хэн нэгэн хүн өөрийнхөө мэдлэгийн хэмжээнд дураараа тайлбар хийж хэрхэвч болохгүй. Тухайлбал “үхэр” гэдэг үгийг тайлбарлахын тулд юуны өмнө монгол хүний сэтгэл зүйд хадгалагдан ирсэн “мал” гэдэг ойлголтыг тодруулан ойлгох хэрэгтэй. Монголчуудын мал гэдэг маань гадаадын олон улс үндэстний гэрийн тэжээвэр гахай, тахиа, нохой, муур, илжиг зэрэг бусад олон амьтдаас ямар ялгаатайг олж “мал” гэдэг үгээ тайлбарласны дараа түүндээ үндэслэн үхэр, адуу, хонь, ямаа, тэмээгээ тайлбарлавал илүү үндэстэй тайлбар болно. Түүнчлэн манан, будан, үүл, хяруу, шүүдэр, цас, бороо, мөндөр гэсэн үгсийг тайлбарлахын тулд тэдний үүсэх үндэс болсон “ус” гэдэг маань ямар утгатай үг вэ? гэдгийг эхлээд тодорхойлох хэрэгтэй болно. Энэ мэтээр тайлбар тольд үгийн утгыг оновчтой тайлбарлахын тулд юуны өмнө тухайн үгтэйгээ утгын холбоотой бүлэг үгсийн хамгийн ерөнхий утгыг илэрхийлдэг үндсэн суурь үгийг /МАЛ, УС гэдэг шиг/ олж тайлбарлах нь маш чухал бөгөөд дараа нь түүн дээрээ тулгуурлан бусад үгийн утгыг тайлбарлахад хялбар болно.

2. Толь бичгүүд, түүний дотор тайлбар толийг ч гэсэн өмнөх толиудынхаа уламжлал, хөрс суурин дээр тулгуурлан зохиодог. Тийм ч учраас хожим зохиосон толь өмнөхөөсөө агуулга, чанарын хувьд зайлшгүй сайжирсан байх шаардлагатай болно. Гэхдээ өмнөх толийнхоо үг оноолт, тайлбар зэргийг шууд хуулбарласан толь байж болохгүй нь ойлгомжтой. Харамсалтай нь, сүүлийн хэдэн жилд толиос төрсөн толь нэг бус гарч байна. Аливаа толь тухайн үеийнхээ хэлний үгийн үндсэн санг илэрхийлж, тухайн үеийнхээ хүмүүст л зориулагдсан байдаг. Бас нэгэн анхаарах зүйл бол УС, МОД, ШУВУУ, УРГАМАЛ, ХООЛ, УНД, ХУВЦАС, ДЭЛГҮҮР, НОМ, ШИРЭЭ гэх мэтийн дэлхийн хаана ч, аль ч хэлэнд байдаг, хүн бүхний мэддэг олон мянган үгсийг тайлбарлах нь амар юм шиг зарим хүмүүс санадаг. Учир нь тэднийг аль нэгэн гадаад хэлний нэр хүндтэй тайлбар толиос орчуулаад авчих юм шиг боддог. Аль ч хэлэнд байдаг, хүн бүхний мэддэг түгээмэл үгийн тайлбарыг бусад хэлний сайн толь бичгээс үлгэр авч болохыг үгүйсгэхгүй. Гэхдээ аль ч хэлний үг бүхэнд тэрхүү үндэстэн, ард түмний сэтгэл зүй, аж амьдрал, нийгмийн нь өвөрмөц онцлог ямар нэгэн хэмжээгээр туссан байдаг учир хэл бүрд утгын ялгаа бага ч гэсэн гарч байдаг. Тэрхүү ялгааг л олж тайлбартаа тусгаж чадвал тухайн хэлний тайлбар толь болж чадна.

3. Өнөөдрийн монгол хэл шинжлэлд нэг болон хамтарсан зохиогчтой олон төрөл зүйлийн том жижиг толь бичгүүд хэвлэгдэн гарч байгаа боловч толь бичгийн ололт, дутагдлыг шинжилсэн судалгааны ажил харьцангуй сул хөгжилтэй байна. Тухайлбал монгол хэл шинжлэлийн толь бичгүүдийн толгой үгийг хэрхэн сонгох, толгой үгийн хэл зүйн хэлбэржилт ямар байх, толгой үгийн үндсэн утгыг хэрхэн тайлбарлах, үгийн олон утгыг хэрхэн гаргах, жишээг хэрхэн авах, тольд ямар тэмдэг тэмдэглэгээ хэрэглэх зэргээс эхлэн маш олон асуудлаар тодорхой судалгаа хийж сургалт – арга зүйн гарын авлага бэлтгэх шаардлагатай байна. Мөн шинээр хэвлэгдэн гарч байгаа толь бүхэнд биш юм гэхэд зарим томоохон тольд зориулсан эрдэм шинжилгээний шүүмж бичиж байх хэрэгтэй байна. Эрдэм шинжилгээний шүүмж бол ололтоо бататгаж, алдсанаа засах чухал хэрэглүүр билээ.

4. Аливаа хэлний хөгжлийн явцад үгийнх нь үндсэн утга харилцан адилгүй хугацаанд өөрчлөгддөг ажээ. Тухайлбал байгаль- цаг уур, газар зүйн байдал, эрхэлдэг аж

ахуй, амьдралын нь суурь хэв шинжтэй холбоо бүхий үгсийн үндсэн утга хэдэн мянган жилд ч онцын өөрчлөлтгүй хадгалагдаж ирдэг бол нийгэм улс төр, үзэл суртал, оюун санааны амьдралтай нь холбоотой үгсийн үндсэн утга түүнээс олон дахин бага хугацаанд хувиран өөрчлөгддөг. Тийм учраас **удаан хугацааны турш утга нь өөрчлөгдөлгүй хадгалагдаж байдаг үгийн хувьд тухайн толийг нэг хоёр зуун жилийн өмнө зохиосон, эсвэл өнөө үед зохиосон уу гэдэг цаг хугацааны ялгаа бараг байхгүй** гэж хэлж болно. Харин нэг хэлний олон тайлбар толь нэг үгийг харилцан адилгүй тайлбарласан байдаг нь бидний эш татсан дээрх жишээнүүдээс тодорхой харагдаж байна. Энэ бол нэгдүгээрт зохиогч бүрийн хувийн онцлогтой, хоёрдугаарт толийг зохиосон цаг үе, нийгмийн нь байдалтай холбогдоно.

НОМЗҮЙ

1. BRITANNICA ширээний нэвтэрхий толь. НЕРКО. УБ. 2011 он,
2. Большой Энциклопедический словарь, М. 2000/
3. Монголын нэвтэрхий толь I, II боть, УБ. 2000 он
4. "THE CONCISE OXFORD DICTIONARY OF CURRENT ENGLISH"
Edited by H. W. FOWLER and F. G. FOWLER based on The Oxford Dictionary. Fifth edition Oxford University Press, 1964.
5. Словарь русского языка, в четырех томах, Москва. 1981
6. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Таван боть, Ерөнхий редактор Л. Болд, УБ. 2008 он
7. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966 он
8. Монгол хэлний толь. Эрхлэн найруулагч Ц. Норжин, Ман. Мөрөн. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999 он
9. Монгол-орос дэлгэрэнгүй их толь. Дөрвөн боть, Хариуцлагатай редактор Г. Ц. Пюрбеев, М. "ACADEMIA" 2001 он.
10. Монгол үгний тайлбар толь. Шагж найруулан зохиов. Монгол улсын Соёлын сан, Дундад улсын үндэстний хэвлэлийн хороо. 1998 он.
11. Хорин нэгт тайлбар толь. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1979 он
12. Хорин наймт тайлбар толь. Намжилмаа эмхлэв. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1994 он
13. Монгол улсын Байгаль орчны яамны Ус цаг уур орчны мониторингийн улсын алба, Ус цаг уурын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гаргасан "Ус цаг уурын албаны заавар" XIV дэвтэр. УБ. 1995 он. II хэвлэл

SUMMARY

This article aims at analyzing words that commonly appear in all languages, for example: **ус** (water), **уур** (steam), **үүл** (cloud), **манан** (fog), **будан** (mist), **хур** (precipitation), **бороо** (rain), **мөндөр** (hail), **цас** (snow), **мөс** (ice), **шүүдэр** (dew), **хяруу** (frost), **цан** (hoar-frost), **хүүрэг** (hoar-frost), etc. It has been to show how these words have explained in Mongolian explanatory dictionaries. According to the conducted study, suggestions have been presented on how these words, shared by all languages of the world, can be explained in Mongolian explanatory dictionaries.